



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2017 оны 9 дүгээр
сарын 7-ны өдөр

Дугаар 245

Улаанбаатар
хот


Орон сууц хувьчлах тухай

Орон сууц хувьчлах тухай хуулийн 6 зүйлийн дугаар 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Монголын төмөр зам” ТӨХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар баригдсан Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь “Шилжүүлэн ачих цогцолбор-1”-ийн бүрэлдэхүүн хэсэг болох 60 айлын орон сууц (12 айлын орон сууц бүхий 5 барилга)-ыг одоо эзэмшиж байгаа оршин суугчдад нь хувьчилсугай.

2. Орон сууц хувьчлах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай.

3. Энэхүү тогтоолын 1 дүгээр зүйлд заасан 60 айлын орон сууцны үлдэгдэл өртгийг тооцон гаргаж, тусгай дансанд байршуулах ажлыг зохион байгуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбатад, уг хөрөнгийг зарцуулах асуудлаар японы талтай зөвшилцөхийг Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргилд тус тус даалгасугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Ж.ЭРДЭНЭБАТ

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга

Ж.МӨНХБАТ